Golomt Capital®

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2025.02.17

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн товчооны (BLS) мэдээлснээр, 1-р сард хэрэглээний үнийн индекс (CPI) сарын дүнгээр 0.5%, жилийн дүнгээр 3.0% өслөө.
- Үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) мөн хүлээлтээс өндөр гарсан бөгөөд 1-р сард 0.4%-иар өссөн.
- Broadcom болон TSMC компаниуд Intel-ийг хоёр хуваах боломжийг судалж байна.
- Хятадын засгийн газар Vanke-ийн 6.8 тэрбум ам.долларын санхүүжилтийн дутагдлыг нөхөх төлөвлөгөө боловсруулж байгаа аж.
- Weixin мессежийн аппдаа DeepSeek-ийн маш алдартай хиймэл оюун ухааны загваруудыг нэгтгэж туршиж эхэлсэн тухай мэдээлсэн байна.

S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	**6,678**

АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.02.10-02.16

АНУ-ЫН ИНФЛЯЦ ӨНДӨР ГАРЛАА

Өнгөрөгч долоо хоногийн эдийн засгийн гол үйл явдал нь Лхагва гарагт гарсан инфляцийн мэдээлэл байлаа. АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн товчооны (BLS) мэдээлснээр, 1-р сард хэрэглээний үнийн индекс (CPI) сарын дүнгээр 0.5%, жилийн дүнгээр 3.0% өссөн нь 12-р сарын 0.4% болон 2.9%-тай харьцуулахад нэмэгдсэн үзүүлэлт байв. Орон сууцны өртөг 0.4%-аар өссөн нь сарын нийт өсөлтийн 30%-ийг бүрдүүлжээ. Хүнс, эрчим хүчний үнийг хассан CPI 1-р сард 0.4%-иар өссөн нь 12-р сарын 0.2%-иас өссөн үзүүлэлт байлаа.

Пүрэв гарагт үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) мөн хүлээлтээс өндөр гарсан бөгөөд 1-р сард 0.4%-иар өссөн нь шинжээчдийн 0.3%-ийн таамаглалаас давсан байна. Гэсэн хэдий ч индексийн зарим чухал бүрэлдэхүүн хэсэг болох эрүүл мэндийн үйлчилгээ, нислэгийн тийзний үнэ буурах хандлагатай гарсан нь эерэг үзүүлэлт болжээ.

АНУ-ын Холбооны Нөөцийн банкны дарга Жером Пауэлл Сенатын банкны хорооны гишүүдэд хандан бид инфляцийг бууруулах чиглэлээр ихээхэн ахиц гаргасан ч хараахан хүрээгүй байна хэмээн дурджээ. Түүнчлэн, "одоо бодлогыг хязгаарлагдмал хэвээр байлгахыг хүсэж байна" гэсэн байна. Чикагогийн Холбооны Нөөцийн банкны ерөнхийлөгч Остан Гулсби мөн The New York Times-д өгсөн ярилцлагадаа эдгээр инфляцийн тоо баримтуудыг "сэтгэл түгшээм" хэмээн тодорхойлж, "хэрэв ийм тоо баримт хэд хэдэн сар дараалан үргэлжилбэл, ажил дуусаагүй байна гэсэн үг" хэмээн нэмж хэлжээ. Үүний улмаас дараагийн хүүг бууруулах хүлээлт 9-р сараас 12-р сар руу шилжсэн байна.

INTEL-ИЙГ ХОЁР ХУВААХ ХЭЛЭЛЦЭЭР ӨРНӨЖ БАЙНА

Broadcom болон TSMC компаниуд Intel-ийг хоёр хуваах боломжийг судалж байна. Broadcom нь Intel-ийн чипний дизайн, маркетингийн бизнесийг сонирхож байгаа бөгөөд үйлдвэрлэлийн салбарт хамтрах түнш олсон тохиолдолд хэлэлцээрийг үргэлжлүүлэх боломжтой гэж үзэж байна.

TSMC тусдаа судалгаа хийж, Intel-ийн үйлдвэрийг эзэмших хувилбарыг судалж байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдын консорциумын хүрээнд эсвэл өөр зохион байгуулалтаар хэлэлцэх боломжтой гэж мэдээлжээ.

АНУ-ын Цагаан ордон Intel-ийн үйлдвэрүүдийг гадаадын компаниуд ажиллуулахыг дэмжих магадлал багатай гэж албаныхан мэдэгдсэн бөгөөд АНУ-ын чип үйлдвэрлэлийн чадавхийг хадгалах нь үндэсний аюулгүй байдлын чухал асуудал гэж үзэж байна.

Intel нь АНУ-ын Засгийн газрын 7.86 тэрбум ам.долларын татаас хүртэх болсон ч үйлдвэрлэлээ өргөжүүлэх зорилгоор ихэнх хөрөнгө зарцуулж, санхүүгийн хүндрэлд орсон. Үүний улмаас компани ажлын байрныхаа 15%-ийг цомхотгож, хувьцааны үнэ өнгөрсөн жил 60%-иар унажээ. Энэхүү хэлэлцээрийн үр дүн нь АНУ-ын технологийн салбарын ирээдүйд томоохон нөлөө үзүүлж болзошгүй байна.

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.02.10-02.16

ИМПОРТЫН ТАТВАР НОГДУУЛСАН Ч ХЯТАД ӨСӨЖ БАЙНА

Хятадын эх газрын хөрөнгийн зах зээл АНУ-ын импортын татвар харьцаннуй зөөлөн байж магадгүй гэсэн найдлагаар өсөв. АНУ-ын Трампын засаг 2-р сарын эхээр Хятадын бүтээгдэхүүнд 10%-ийн татвар ногдуулснаас хойш энэхүү хүлээлт үүссэн байна. FactSet-ийн мэдээлснээр, эх газрын CSI 300 индекс 1.19%-иар, Шанхайн нийлмэл индекс 1.30%-иар өсжээ. Харин Хонгконгийн Hang Seng индекс 7.04%-иар огцом өссөн нь хөрөнгө оруулагчид хиймэл оюун ухаантай холбоотой хувьцаануудыг их хэмжээгээр худалдан авсантай холбоотой юм. Эдийн засгийн үзүүлэлтүүдийн хувьд Хятадын хэрэглээний үнийн индекс (CPI) 1-р сард жилийн дүнгээр 0.5%-иар өссөн нь 12-р сарын 0.1%-тай харьцуулахад хүлээлтээс өндөр үзүүлэлт байлаа гэж тус улсын статистикийн товчоо мэдээлэв. 1-р сарын энэхүү өсөлт нь өнгөрсөн 8-р сараас хойших анхны өсөлт бөгөөд найман өдрийн Цагаан сарын баярын өмнөх хэрэглээний өсөлт үүнд нөлөөлсөн байж магадгүй юм. Харин үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) 1-р сард 2.3%-иар буурч, 12-р сарын үзүүлэлттэй адил гарсан ба үйлдвэрүүдийн дефляци 28 дахь сардаа үргэлжилж байна. Дефляцийг дарах асуудал Бээжингийн хувьд улам бүр тулгамдсан асуудал болж байгаа бөгөөд өнгөрсөн 9-р сараас эхлэн эдийн засгийн эрэлтийг дэмжих зорилгоор мөнгөний болон төсвийн олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Гэвч олон жилийн турш үргэлжилсэн орон сууцны салбарын уналт хүмүүсийг хэрэглээнээс илүү хадгаламжинд төвлөрүүлж, засгийн газрын хэрэглээг нэмэгдүүлэх оролдлогод саад болж байна. Moody’s агентлаг үл хөдлөх хөрөнгийн салбарын хүндрэлтэй байгаа China Vanke компанийн зээлийн үнэлгээг дахин бууруулж, хог ангиллын бүс рүү орууллаа. Moody’s уг шийдвэрээ компанийн санхүүгийн үзүүлэлт муудсантай холбон тайлбарлав. Үүний улмаас, төрийн дэмжлэгтэй, "нурашгүй" хэмээгдэж байсан Vanke компанийг дефолт болох эрсдэлтэй гэж үзэх болжээ. Bloomberg агентлагийн Лхагва гарагт мэдээлснээр, Хятадын засгийн газар Vanke-ийн 6.8 тэрбум ам.долларын санхүүжилтийн дутагдлыг нөхөх төлөвлөгөө боловсруулж байгаа аж. Энэ нь бүрэн аврах ажиллагаа биш ч гэлээ, Vanke-ийг 2021 онд дефолт зарласнаас хойш татан буугдсан China Evergrande компанитай ижил хувь тавилан угтахаас сэргийлэх алхам гэж үзэж байна.

ХЯТАДЫН ТЕХНОЛОГИЙН ТОМЧУУД БА DEEPSEEK

Tencent компанийн Хонгконг дахь хувьцаа Даваа гарагт огцом өсөв. Учир нь Weixin мессежийн аппдаа DeepSeek-ийн маш алдартай хиймэл оюун ухааны загваруудыг нэгтгэж туршиж эхэлсэн тухай мэдээлсэн байна. Tencent Holdings Ltd (HK:0700) компанийн хувьцаа 6.6%-иар өсөж, сүүлийн дөрвөн жилийн хамгийн дээд цэг болох 512.0 хонгконг долларт хүрсэн нь Hang Seng индексийн гол өсөлтийг хангажээ. Тус компани DeepSeek AI-ийг ашиглан зарим хэрэглэгчдэд интернэт хайлт хийх боломж олгож эхэлснээ мэдэгдсэн бөгөөд энэ нь DeepSeek-ийг Хятадын хамгийн түгээмэл мессежийн апп-д нэгтгэх томоохон алхам болж байна.

Үүнээс гадна, Baidu (NASDAQ:BIDU) Inc (HK:9888) компани ч DeepSeek болон өөрийн Ernie AI загварыг ашиглан интернэт хайлт хийх боломжийг хэрэглэгчдэд олгохоор болсноо зарласан. Гэвч Baidu-ийн Хонгконг дахь хувьцаа 6%-иар унасан нь хөрөнгө оруулагчид тус компанийн энэ долоо хоногт гарах улирлын тайлангийн өмнө ашиг хураан авах шийдвэр гаргасантай холбоотой байна.

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд